



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9, 6.9.3, Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журмын 2 дугаар зүйлийн 2.3.1, "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК-ийн 2026 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн №25/05 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гишүүн "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК (Б.Өлзийбаяр)-д Үнэт цаасны арилжаанд оролцох FIХ эрх шинээр олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан ажилтанд, Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.
4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БИЗНЕС
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ



ХАШ-ЭРДЭНЭ

1526030039

“Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК-ийн ажилтан Б.Өлзийбаяр нь үнэт цаасны арилжаанд оролцох FIX эрх олгох журмын шаардлага хангасан эсэх

Д/д	Журмын шаардлага	Хангасан эсэх
1	СЗХ-ноос “Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны зуучлалын чиглэлээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх”-ийн үнэмлэхийн хугацаа хүчинтэй байх:	Үнэмлэхийн дугаар: 220607188 Хүчинтэй хугацаа: Хугацаагүй
2	Эрх олгох ажилтан нь гишүүн ҮЦК-ийн захирал, брокер, дилерийн аль нэг албан тушаалд томилогдсон, 3 ба түүнээс дээш сарын хугацаанд үндсэн үйл ажиллагааг хариуцан ажиллаж дадлагажсан байх:	Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх байгууллагад 3 сараас дээш хугацаанд ажилласан туршлага хангасан
3	Сүүлийн 6 сарын дотор журмын 3.1, 3.3-д заасан арга хэмжээ авагдаагүй байх:	Авагдаагүй байна
4	Үйлчилгээний хөлс 20,000, Терминалын хураамж 195,000 төгрөг төлсөн баримт:	2026.01.13-нд шилжүүлсэн
5	Утасны дугаар:	99103838